



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and  
Competitiveness Project

# ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2008 оны 1, 2 дугаар сар

## Монгол Улсыг Хойд Америкийн зах зээл дээр сурталчлан таниулах арга хэмжээг Нью Йорк хотноо болсон сэтгүүлчдэд зориулсан өглөөний цайны үеэр зохион байгуулав

Хойд Америкийн зах зээл дээр Монгол Улсыг зорих газраар сурталчлан таниулах арга хэмжээ энэ оны 2 дугаар сарын 29-ний өдөр Нью Йорк Таймсын аялал жуулчлал, худалдааны үзэсгэлэнгийн нээлтийн ажиллагааны үеэр сэтгүүлчдэд зориулан зохион байгуулсан өглөөний цайны үеэр болсон бөгөөд уг арга хэмжээнд аялал жуулчлалын салбарын



тэргүүлэх байгууллага, хэвлэл мэдээллийн газрын 59 сэтгүүлч, удирдах ажилтнууд оролцлоо.

Уг арга хэмжээн дээр НҮБ-ын Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн газрын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Очирын Энхцэцэг, Америкийн аялал жуулчлалын нийгэмлэгийн тэргүүн ноён Давид Перри нар гол илтгэлүүдийг тавьж, Зам, тээвэр, аялал жуулчлалын яам (ЗТАЖЯ), Үндэсний аялал жуулчлалын байгууллага (ҮАЖБ) ба хувийн тур операторуудаас бүрдсэн монголын төлөөлөгчдөд олон асуулт тавьж тэд хариулт өгөв.

Үүнээс гадна Нэшинал Жеографик сэтгүүлийн аялал жуулчлал хариуцсан захирал Брайн Кинкейд, ахлах редактор Майк Бенуа нар энхүү өглөөний цайны үеэр презентаци тавьсан нь онцлох үйл явдал болов. Мөн Брэдфорд групптэй хамтран үйл ажиллагаа явуулах ҮАЖБ-ын АНУ дахь офисын нээлтийн ажиллагаа боллоо. Энэхүү офис нь аялал жуулчлалын сэдэвт нийтлэлд Монголын талаар гаргах сонирхолтой тус салбарын мэргэжлийнхэнд үйлчлэх газар байх юм. Ялангуяа 2008 онд Монголд нарны хиртэлт болох гэж байгаа нь энэ зуны олон нийтлэлийн гол сэдэв байх болно. Иймд энэхүү арга хэмжээг эрчимжүүлж, цаашид өргөжин тэлж буй аялал жуулчлалын хүрээг бататгаж мөн АНУ-ын зах зээлд эрчтэй гарах үүднээс ҮАЖБ нэр хүнд бүхий дараах гурван байгууллагын гишүүнээр элсэв. Үүнд: АНУ-ын Тур операторуудын нийгэмлэг, Америкийн Аялал жуулчлалын

нийгэмлэг ба Адал явдалт аялал жуулчлал, худалдааны нийгэмлэг.

2007 оны 11 дүгээр сард Лондон хотноо болсон Дэлхийн аялал жуулчлалын үзэсгэлэн яармагийн үеэр тохиролцож эхэлсэнээс хойш ҮАЖБ Хойд Америкийн зах зээл дээр Монгол Улсыг сурталчлах 18 сарын кампанит ажлыг зохион байгуулах зорилгоор 2008 оны 1 дүгээр сард Нью Йоркт төвтэй олон нийтийн харилцаа, маркетингийн Брэдфорд групптэй гэрээ байгууллаа.

Брэдфорд групптэй гэрээ байгуулан гарын үсэг зурж, Нэшинал Жеографик адал явдалт аялал жуулчлалын сэтгүүлийн "2008 оны шилдэг адал явдалт зорих газар" шагналыг хүртсэн нь Монгол Улсыг Хойд Америкийн зах зээл дээр цаашид сурталчлан таниулахад чухал үйл явдал боллоо.

## Худалдааны зуны сургалтанд оролцогчдоос тэтгэлэг авах судалгааны ажлын сүүлийн шалгаруулалтын дүнг гаргав

Худалдааны бодлогын талаарх судалгааны ажилд амжилттай оролцсон оролцогчдод шагнал гардуулах арга хэмжээ 2 дугаар сарын 28-нд зохион байгуулагдаж, ҮХЯ-ны Эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга В.Энхболд, ЭЗБШӨЧ төслийн удирдагч ноён Фернандо Бертоли нар шалгарсан оролцогчдод тэтгэлэг гардууллаа.



Тэтгэлэг гардуулах энэхүү арга хэмжээг өмнөх зуны худалдааны сургалтанд оролцож Монголын худалдааны бодлогын талаар судалгаа хийсэн оролцогчдод дэмжлэг үзүүлэх зорилгоор Германы техникийн хамтын нийгэмлэг (GTZ), АНУ-ын ОУХА/ЭЗБШӨЧ төслөөс хамтран

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

санхүүжүүлсэн болно. ҮХЯ, GTZ болон ЭЗБШӨЧ төслийн төлөөлөгчид багтсан техникийн хороо ирүүлсэн саналуудад үнэлгээ өгч, эцсийн шалгаруулалтын дүнг гаргалаа.

Дараах ажлуудыг худалдааны бодлогын талаар хийсэн судалгааны шилдэг ажлаар шалгаруулжээ: Үүнд

- Төмсний үнийн бодлого ба худалдааны анализ (Ш.Дэнсмаа, Б.Пүрэв, С.Хандсүрэн)
- Гравитацийн загвар ашиглан Монгол Улсын экспортыг загварчлах нь (С.Болд)
- Монголын үйлчилгээний худалдааны хөгжил (Н.Өнөржаргал)
- Монгол Улсын агаарын тээврийн үйлчилгээний худалдаан дахь хязгаарлалтууд (С.Болд)

Эдгээр судалгааны ажлуудыг ҮХЯ өөрийн вэбсайтад байрлуулж, ЭЗБШӨЧ төсөлтэй хамтран бодлого боловсруулагчид болон олон нийтэд судалгааны үр дүнгийн талаар танилцуулж ярилцлага зохион байгуулахаар төлөвлөж байна.

## Түлш, эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах газар Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа

1 дүгээр сарын 29-ний өдөр Түлш, эрчим хүчний сайд Ч. Хүрэлбаатар, Эрчим хүчний зохицуулалтын газрын Зохицуулагчдын зөвлөлийн дарга Р. Ганжуур нар Монгол улсын эрчим хүчний салбарын үйл ажиллагаа, шинэтгэлийн асуудлаархи хамтын ажиллагааны Харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ)-т гарын үсэг зурав.

ХОСБ-ийн зорилго нь "эрчим хүчний салбарын бодлого, стратеги, салбарын зохицуулалт, зохицуулалтын шинэтгэлийн зарим асуудлууд, тэдгээрийг хэрэгжүүлэхэд Талуудын хамтын ажиллагааг сайжруулахад" оршиж байна. Тодруулбал ХОСБ-ийн дагуу талууд дараахь үүрэгтэйгээр хамтран ажиллах юм. Үүнд:

- Цахилгаан, дулааны үнэ тарифыг боловсронгуй болгох хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах
- Аж ахуйн нэгж, байгууллагууд болон ахуйн хэрэглээний цахилгааны цагийн ялгавартай тарифыг шинэчлэх
- Ахуйн цахилгаан хэрэглэгчдийн амьжиргааны түвшний тарифыг шинээр боловсруулж хэрэгжүүлэх
- Аж ахуйн нэгж, байгууллага, ахуйн хэрэглэгчдийн ангиллыг шинэчлэх
- Хэрэглэгчдийн цахилгаан, дулааны үнэ тарифын зохицуулалтын тооцоо судалгааг хийх
- Эрчим хүч үйлдвэрлэлтийн хоёр-хэсэгтэй үнэ тарифын аргачлалыг батлан, мөрдөж эхлэх хугацааг товлох
- Гүйцэтгэлийн гэрээний (ГГ) загварыг боловсронгуй болгож, сонирхсон тусгай зөвшөөрөл бүхий 2-3 компаниар гүйцэтгүүлэх
- Эрчим хүчний компаниудын орлого, зардлын аудитыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай (НББОУС) нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Алслагдсан аймаг, сумдын цахилгаан түгээх сүлжээнүүдийн алдагдлыг хэрэглэгчдэд төрөөс татаас олгох замаар шийдвэрлэх боломжийг судалж, эрх бүхий холбогдох газруудад саналаа тавих
- Түлш, эрчим хүчний сайдын Зөвлөлийн хурлаар дараахь асуудлуудыг оруулж хэлэлцүүлэх:

Зах зээлийн загварыг боловсруулах

Зах зээлийн дүрмийг боловсруулах

Зах зээлийн шинэ загварыг хэрэгжүүлэх

Төслийн туслалцаатайгаар боловсруулсан ХОСБ нь 2009 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд ТЭХЯ нь ЭХЗГ-аас Эрчим хүчний хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Түлш, эрчим хүчний сайдын санаачлагаар байгуулсан энэхүү ХОСБ зохих ёсоор хэрэгжвэл эрчим хүчний салбарт урт хугацааны туршид үргэлжилж буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд тус болохуйц шаардлагатай хүрээ тогтолцоогоор хангах юм.

## Татварын албадын ажилтнуудад зориулсан мэдээллийн аюулгүй байдал, татварын цахим тайлангийн систем, шинэ дүрэм журмын талаар хоёр өдрийн сургалт семинар боллоо

Дархан-Уул аймгийн Татварын албаны Сургалтын төвд 2-р сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан хоёр өдрийн сургалт семинарт Төв, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл аймгийн 40 гаруй татварын улсын байцаагчид, эдийн засагчид оролцов. Энэхүү сургалт семинарыг Монголын Үндэсний татварын ерөнхий газар (МҮТЕГ), Төслөөс хамтран зохион байгуулсан. Дотоод сүлжээний суурилуулалт, тохируулга, аюулгүйн асуудлуудаархи эхний өдрийн практик сургалтад зориулж МҮТЕГ-аас 15 компьютерийг бэлтгэснийг ЭЗБШӨЧ төсөл дотоод сүлжээнд холбон тохируулга хийв. Энэ өдөр дараахь сэдвүүдээр сургалт явууллаа: дотоод сүлжээний ажиллагаа, интернетийн хэрэглээ, e-мэйлээр харилцах, системийн зохистой ажиллуулах. Хэдийгээр сургалтын цаг хугацаа богино байсан ч оролцогчид сургалтын зааварт хэрэглэсэн үр дүнтэй, шат ахиулан сургасан сургалтын арга техникт сэтгэл хангалуун байснаа илэрхийлсэн юм.



Сургалт семинарын хоёрдахь өдөр Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын хууль болон татварын бусад асуудлуудтай холбогдуулан гаргасан шинэ дүрэм журмуудыг танилцуулав. Түүнчлэн сургалтад оролцогчид ойрын хугацаанд үндэсний хэмжээнд нэвтрүүлэх татварын мэдээллийн сан, цахим татварын тайлангийн тогтолцооны бүтэц, ажиллах урсгалын талаар тодорхой мэдээлэл авлаа.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал харууцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.  
И-мэйл [fbertoli@eprc-chemonics.biz](mailto:fbertoli@eprc-chemonics.biz), факс: (976-11) 32 78 25.